

ТАНИЛЦУУЛГА

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Дэлхийн худалдааны байгууллагын 130 дахь гишүүн болсноор тус байгууллагын гишүүн 164 оронтой нэн тааламжтай нөхцөлөөр худалдаа хийх, гишүүн орнуудын худалдааны бодлого, баримт бичгүүдийн мэдээллээр хангагдах, өөрийн улсын эрх ашгийг хамгаалах, техник туслалцааны хүрээнд дэмжлэг авах боломж бүрдсэн.

Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр” нь 1980 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд 32 улс нэгдсэн орсон. Хэлэлцээр нь цэргийн зориулалттайгаас бусад иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон холбогдох тоног төхөөрөмжийн худалдаанд үүсч байгаа бэрхшээлийг арилгах, тоног төхөөрөмж, эд ангийг гаалийн болон худалдааны татвар, хураамжаас чөлөөлөх зорилготой.

Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.2-т “Иргэний нисэхийн салбарыг даяарчлагдсан дэлхийн иргэний агаарын тээврийн бүрдэл болгох, бүс нутагтаа тэргүүлэх орнуудын хэмжээнд хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарт тооцож, төрийн бодлогоор дэмжинэ” гэсэн зарчмыг тодорхойлж, мөн бодлогын баримт бичгийн 7.2-т “Агаарын тээврийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын хөлгийг гаалийн татвараас хөнгөлж, чөлөөлөх бодлого баримтална.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2.-т заасан “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” зорилтын хүрээнд 2020-2030 онд иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлсэн байх, Засгийн газрын 2018 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-т ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэд хувийн хэрэгцээндээ зориулан агаарын хөлөг, нисдэг тэрэг авч ашиглахад татварын дэмжлэг үзүүлэх зохицуулалт бүрдүүлэхээр тус тус тусгасан.

Монгол Улс 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орсон бөгөөд уг хэлэлцээрийн 2.1.1-т зааснаар “Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлэх өдрөөс эхлэн гаалийн зориулалтаар Хавсралт дахь жагсаалтад харгалзах тарифын гарчигийн дагуу ангилсан бүтээгдэхүүн болон үйлдвэрлэл, засвар, үйлчилгээ, сэргээн босголт, өөрчлөлт, эсхүл хувиргалтын явцад агаарын хөлөг, эсхүл түүний угсралтад ашиглах бүтээгдэхүүний импортод ногдуулах, эсхүл түүнтэй холбогдох бүхий л гаалийн татвар болон бүх төрлийн бусад хураамжийг арилгахыг” нэгдэн оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн болно.

Мөн 9.4-т зааснаар нэгдэн оролцогч тал нь уг хэлэлцээрийг тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө өөрийн хууль тогтоомж, захиргааны журмыг энэ хэлэлцээртэй нийцүүлэх үүрэг хүлээсэн.

Зөвхөн зорчигч тээврийн зориулалтаар үйлдвэрлэсэн агаарын хөлгийг нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлж буй зохицуулалт нь ерөнхий зориулалтын болон ачаа тээврийн агаарын хөлөгт хамаарахгүй байгаа тул Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.9-д заасан “иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг”-ийг татвараас чөлөөлж буй зохицуулалтыг өөрчлөн “бүх төрлийн иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр, газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийг татвараас чөлөөлөх” зохицуулалт бүрдүүлж, холбогдох татварын хууль тогтоомжийг “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нийцүүлэх шаардлагатай болно.

“Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн 9.4.2-т зааснаар нэгдэн оролцогч тал нь хэлэлцээртэй холбоотой өөрийн хууль тогтоомж болон тэдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд орсон аливаа өөрчлөлтийн талаар Зөвлөлд мэдэгдэх бөгөөд 9.3.1-т зааснаар Хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс хойш 30 дахь өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

Монгол Улсын тухайд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсны дараа дотоодын хууль тогтоомж, захиргааны журмыг энэ хэлэлцээрт нийцүүлсэн талаар Дэлхийн худалдааны байгууллагын Зөвлөлд мэдэгдэж, хүчин төгөлдөр болгох ажиллагаа хийх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

“ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс 1997 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Дэлхийн худалдааны байгууллагын 130 дахь гишүүн болсноор тус байгууллагын гишүүн 164 оронтой нэн тааламжтай нөхцөлөөр худалдаа хийх, гишүүн орнуудын худалдааны бодлого, баримт бичгүүдийн мэдээллээр хангагдах, өөрийн улсын эрх ашгийг хамгаалах, техник туслалцааны хүрээнд дэмжлэг авах бололцоо бүрдсэн.

Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр” нь 1980 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд 32 улс нэгдсэн орсон. Хэлэлцээрийн гол зорилго нь цэргийн зориулалтаас бусад иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон холбогдох тоног төхөөрөмжийн худалдаанд үүсч байгаа бэрхшээлийг арилгах, хавсралтад тусгагдсан тоног төхөөрөмж, эд ангийг гаалийн болон худалдааны татвар, хураамжаас чөлөөлөх зохицуулалтыг тусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.2-т “Иргэний нисэхийн салбарыг даяарчлагдсан дэлхийн иргэний агаарын тээврийн бүрдэл болгох, бүс нутагтаа тэргүүлэх орнуудын хэмжээнд хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарт тооцож, төрийн бодлогоор дэмжинэ” гэсэн зарчмыг тодорхойлж, мөн бодлогын баримт бичгийн 7.2-т “Агаарын тээврийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын хөлгийг гаалийн татвараас хөнгөлж, чөлөөлөх бодлого баримтална.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2.-т заасан “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” зорилтын хүрээнд 2020-2030 онд иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлсэн байх зорилго, Засгийн газрын 2018 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-т ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэд хувийн хэрэгцээндээ зориулан агаарын хөлөг, нисдэг тэрэг авч ашиглахад татварын дэмжлэг үзүүлэх зохицуулалт бүрдүүлэхээр тус тус тусгасан.

Монгол Улс 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орсон. “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн 2.1.1-т зааснаар “Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлэх өдрөөс эхлэн гаалийн зориулалтаар Хавсралт дахь жагсаалтад харгалзах тарифын гарчигийн дагуу ангилсан бүтээгдэхүүн болон үйлдвэрлэл, засвар үйлчилгээ, сэргээн босголт, өөрчлөлт, эсхүл хувиргалтын явцад агаарын хөлөг, эсхүл түүний угсралтад ашиглах бүтээгдэхүүний импортод ногдуулах, эсхүл түүнтэй холбогдох бүхий л гаалийн татвар болон бүх төрлийн бусад хураамжийг арилгахыг” нэгдэн оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн болно.

Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн 9 дүгээр зүйлийн 9.4-т зааснаар нэгдэн Оролцогч тал нь уг Хэлэлцээрийг тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө өөрийн хууль тогтоомж, захиргааны журмыг энэ Хэлэлцээртэй нийцүүлэх үүрэг хүлээсэн.

Үүнтэй холбогдуулан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9-д заасан “иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг” гэснийг өөрчлөн бүх төрлийн иргэний агаарын хөлгийг татвараас чөлөөлөх зохицуулалт бүрдүүлж, татварын хууль тогтоомжийг “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нийцүүлэхээр байгаа болно.

Иргэний агаарын зорчигч тээврийн хөлгийг гаалийн татвараас чөлөөлж буй зохицуулалт нь зөвхөн зорчигч тээврийн зориулалтаар үйлдвэрлэсэн агаарын хөлөгт хамаарч байгаа нь ерөнхий зориулалтын болон ачаа тээврийн агаарын хөлөгт хамаарахгүй байгаа юм.

“Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.2-т зааснаар нэгдэн Оролцогч тал нь Хэлэлцээртэй холбоотой өөрийн хууль тогтоомж болон тэдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд орсон аливаа өөрчлөлтийн талаар Зөвлөлд мэдэгдэх, 9.3.1-т зааснаар Хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс хойш 30 дахь өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

Монгол Улсын тухайд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулсны дараа дотоодын хууль тогтоож, захиргааны журмыг энэхүү Хэлэлцээрт нийцүүлсэн талаар Дэлхийн худалдааны байгууллагын Зөвлөлд мэдэгдэж, хүчин төгөлдөр болгох ажиллагаа хийх юм.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулан, Засгийн газрын гишүүдээс саналыг авч, хуулийн төсөлд тусгаж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу холбогдох зөвшөөрлийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

---oOo---

